

22

**ГОВИЙН ӨНДӨР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 1

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ин гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн "Говийн өндөр" ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. "Говийн Өндөр" Хувьцаат компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



П.ЭРДЭНЭЦЭЦЭГ

88

**ГОВИЙН ӨНДӨР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 2

Улаанбаатар хот

2018 оны компанийн бизнес төлөвлөгөөг батлах тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.15-д заасныг үндэслэн "Говийн Өндөр" ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. "Говийн өндөр" хувьцаат компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.
2. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой банкнаас зээл авах, түүнтэй холбоотой компанийн хөрөнгийг барьцаалах зэрэг компанийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай шийдвэр гаргах эрхийг ТУЗ-д олгосугай
3. Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавихыг ТУЗ-ийн гишүүдэд, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх захирал П.Батбаяр үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



П.ЭРДЭНЭЦЭЦЭГ

84

**ГОВИЙН ӨНДӨР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 3

Улаанбаатар хот

*Нэмж хувьцаа гаргах тухай,
хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай:*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дах заалт, "Говийн Өндөр" ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Нэмж хувьцаа гаргах төслийг 2018 онд хэрэгжүүлэхгүй байхаар тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА



П.ЭРДЭНЭЦЭЦЭГ

28

ГОВИЙН ӨНДӨР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 5

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах заалт, "Говийн Өндөр" ХК –ийн 2018 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. "Говийн Өндөр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүнээр:

1. Пандь овогтой Эрдэнэцэцэг
2. Пандь овогтой Батбаяр
3. Пандь овогтой Эрдэнэчимэг
4. Пандь овогтой Түмэнбаяр
5. Пандь овогтой Ишдорж
6. Пандь овогтой Рэнцэнхорол

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнээр:

1. Самбуу овогтой Булган
 2. Дашням овогтой Отгонбаяр
 3. Эрдэнцог овогтой Чойхүү
- нарыг тус тус сонгосугай.

2. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

П.ЭРДЭНЭЦЭЦЭГ

95

**ГОВИЙН ӨНДӨР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 4

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг батлах тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.1-д заасныг үндэслэн "Говийн Өндөр" ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. "Говийн Өндөр" ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /П.Батбаяр/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

П.ЭРДЭНЭЦЭЦЭГ